



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Сүхбаатар аймгийн Молцог илч ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СБА-2024/14/НА-СТА-ОНА

|  |   |
|--|---|
| <p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br/>Баруун-Урт сум<br/>2024 он</p> | <p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br/>тэргүүлэх аудитор: Г.Даваа<br/>Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn<br/>Аудитын менежер: М.Нарантуяа<br/>Утас: 70512127 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn<br/>Аудитор: Б.Мөнхбамбар<br/>Утас: 70512123 Цахим хаяг: munkhbambarb@audit.gov.mn</p> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

МОЛЦОГ ИЛЧ ОНӨААТҮГ ЗАХИРАЛ  
Т.ДЭЛГЭРЦОГТ ТАНАА

2024.03.15 № 226  
танай \_\_\_\_\_ - ны№ \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Наран сумын Молцог илч ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Наран сумын Молцог илч ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны А/18 тоот тогтоолоор 2023 оны 10 сарын 1-ний өдрөөс эхлэн үнэ тарифыг мөрдөхөөр шинэчлэн батлуулсан.

### Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Наран сумын Молцог илч ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаар 3,100.3 мянган төгрөгийн ашигтай байна. Энэ нь хуримтлагдсан алдагдал 6,453.5 мянган төгрөг болж буурсан бөгөөд ашигтай ажиллахад айл өрх, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын халаалт дулааны үнэ тариф өссөн, мөн үр ашиггүй зардлыг бууруулсан нь нөлөөлжээ.

### Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Наран сумын Молцог илч ОНӨААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулжээ. Сумын Засаг даргатай гэрээ байгуулж, гүйцэтгэлийг 86 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код          | Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл       | Эцсийн үлдэгдэл       |
|--------------|--|----------------------|-----------------------|
| <b>1</b>     | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                     | <b>3,991,009.82</b>  | <b>5,463,865.97</b>   |
| <b>31</b>    | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                              | <b>11,914.09</b>     | <b>157,265.97</b>     |
| <b>31200</b> | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>                  | <b>11,914.09</b>     | <b>157,265.97</b>     |
| <b>31210</b> | <b>Төгрөг</b>                                      | <b>11,914.09</b>     | <b>157,265.97</b>     |
| 31213        | Арилжааны банк дахь харилцах                       | 11,914.09            | 157,265.97            |
| <b>33</b>    | <b>АВЛАГА</b>                                      | <b>812,495.73</b>    | <b>0</b>              |
| 33401        | Дансны авлага /ТӨҮГ/                               | 812,495.73           | 0                     |
| <b>35</b>    | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                              | <b>3,166,600.00</b>  | <b>5,306,600.00</b>   |
| <b>35400</b> | <b>Хангамжийн материал</b>                         | <b>3,166,600.00</b>  | <b>5,306,600.00</b>   |
| 35420        | Аж ахуйн материал                                  | 3,166,600.00         | 5,306,600.00          |
| <b>2</b>     | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                 | <b>2,012,500.00</b>  | <b>88,336,365.62</b>  |
| <b>39</b>    | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                              | <b>2,012,500.00</b>  | <b>88,336,365.62</b>  |
| <b>39200</b> | <b>Биет хөрөнгө</b>                                | <b>729,166.67</b>    | <b>87,493,032.29</b>  |
| 39203        | Авто-тээврийн хэрэгсэл                             | 0                    | 88,540,138.74         |
| 39204        | Хуримтлагдсан элэгдэл                              | 0                    | -4,236,689.79         |
| 39205        | Машин тоног төхөөрөмж(компьютер)                   | 750,000.00           | 3,850,000.00          |
| 39206        | Хуримтлагдсан элэгдэл                              | -20,833.33           | -660,416.66           |
| <b>39300</b> | <b>Биет бус хөрөнгө</b>                            | <b>1,283,333.33</b>  | <b>843,333.33</b>     |
| 39301        | Програм хангамж                                    | 1,320,000.00         | 1,320,000.00          |
| 39302        | Хуримтлагдсан элэгдэл                              | -36,666.67           | -476,666.67           |
| <b>3</b>     | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                 | <b>6,003,509.82</b>  | <b>93,800,231.59</b>  |
| <b>4</b>     | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                              | <b>15,557,370.00</b> | <b>100,473,764.28</b> |
| <b>41</b>    | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                   | <b>15,557,370.00</b> | <b>100,473,764.28</b> |
| <b>41300</b> | <b>Өглөг</b>                                       | <b>15,557,370.00</b> | <b>14,336,982.00</b>  |
| <b>41360</b> | <b>Бусад өглөг</b>                                 | <b>15,557,370.00</b> | <b>14,336,982.00</b>  |
| 41366        | Дансны өглөг /ТӨҮГ/                                | 15,557,370.00        | 14,336,982.00         |
| <b>41400</b> | <b>Урьдчилж орсон орлого</b>                       | <b>0</b>             | <b>86,136,782.28</b>  |
| 41440        | Бусад урьдчилж орсон орлого                        | 0                    | 86,136,782.28         |
| <b>5</b>     | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                    | <b>-9,553,860.18</b> | <b>-6,673,532.69</b>  |
| <b>51</b>    | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                 | <b>-9,553,860.18</b> | <b>-6,673,532.69</b>  |
| <b>51200</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                        | <b>-9,553,860.18</b> | <b>-6,673,532.69</b>  |
| 51210        | Өмнөх үеийн үр дүн                                 | 0                    | -9,553,860.18         |
| 51220        | Тайлант үеийн үр дүн                               | -9,553,860.18        | 2,880,327.49          |
| <b>6</b>     | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | <b>6,003,509.82</b>  | <b>93,800,231.59</b>  |

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

| Код        | Үзүүлэлт                               | ӨМНӨХ ОН             | ТАЙЛАНТ ОН           |
|------------|--|----------------------|----------------------|
| <b>I</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b> | <b>16,141,631.22</b> | <b>52,639,099.59</b> |
| <b>12</b>  | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>             | <b>16,141,631.22</b> | <b>52,639,099.59</b> |
| <b>120</b> | <b>Нийтлэг татварын бус орлого</b>     | <b>16,141,631.22</b> | <b>52,639,099.59</b> |
| 120010     | Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/     | 73,775,526.80        | 210,820,820.26       |
| 120011     | Борлуулалтын өртөг /ТӨҮГ/              | 57,633,895.58        | 158,181,720.67       |
| <b>II</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>     | <b>25,695,491.40</b> | <b>49,758,772.10</b> |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                   | <b>25,695,491.40</b> | <b>49,758,772.10</b> |
| <b>210</b> | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b> | <b>25,695,491.40</b> | <b>49,758,772.10</b> |

|        |  |               |               |
|--------|--|---------------|---------------|
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,695,491.40 | 49,758,772.10 |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/                      | 25,695,491.40 | 49,240,813.09 |
| 210812 | Санхүүгийн зардал /ТӨҮГ/                                 | 0             | 18,200.00     |
| 210814 | Орлогын татварын зардал /ТӨҮГ/                           | 0             | 499,759.01    |
| III    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)                    | -9,553,860.18 | 2,880,327.49  |
| VI     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)          | -9,553,860.18 | 2,880,327.49  |

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт  | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 1   | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 10  | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 0.00                            | 0.00                  | -9,553,860.18     | -9,553,860.18                          |
| 3   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 2   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 4   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 5   | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 6   | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 7   | Өмчид гарсан өөрчилөлт                          | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 8   | Зарласан ногдол ашиг                            | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 9   | Тайлант үеийн үр дүн                            | 0.00                            | 0.00                  | -9,553,860.18     | -9,553,860.18                          |
| 11  | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | 0.00                            | 0.00                  | -9,553,860.18     | -9,553,860.18                          |
| 20  | 2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл           | 0.00                            | 0.00                  | -6,673,532.69     | -6,673,532.69                          |
| 13  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 0.00                            | 0.00                  | -9,553,860.18     | -9,553,860.18                          |
| 12  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 14  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 15  | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 16  | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 17  | Өмчид гарсан өөрчилөлт                          | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 18  | Зарласан ногдол ашиг                            | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| 19  | Тайлант үеийн үр дүн                            | 0.00                            | 0.00                  | 2,880,327.49      | 2,880,327.49                           |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код     | Үзүүлэлт  | ӨМНӨХ ОН      | ТАЙЛАНТ ОН     |
|---------|---|---------------|----------------|
| I       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)              | 70,653,031.07 | 216,183,315.99 |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                 | 70,653,031.07 | 216,183,315.99 |
| 120     | Нийтлэг татварын бус орлого                         | 70,653,031.07 | 216,183,315.99 |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого                    | 666,000.00    | 37,205,562.26  |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих           | 666,000.00    | 37,205,562.26  |
| 120013  | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/ | 69,987,031.07 | 178,977,753.73 |
| II      | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                   | 68,571,116.98 | 214,937,964.11 |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ                                       | 68,571,116.98 | 214,937,964.11 |

|             |  |                      |                       |
|-------------|--|----------------------|-----------------------|
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                             | <b>68,571,116.98</b> | <b>214,937,964.11</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                           | <b>27,216,194.34</b> | <b>75,821,781.14</b>  |
| 210106      | Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/   | 27,216,194.34        | 75,821,781.14         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>              | <b>6,916,378.79</b>  | <b>23,310,450.31</b>  |
| 210206      | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/                      | 6,916,378.79         | 23,310,450.31         |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                   | <b>2,279,843.85</b>  | <b>7,691,633.65</b>   |
| 210305      | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/                                   | 2,279,843.85         | 7,691,633.65          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                            | <b>28,514,092.00</b> | <b>69,527,105.00</b>  |
| 210409      | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/ | 11,728,392.00        | 36,559,655.00         |
| 210410      | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/                       | 16,785,700.00        | 32,967,450.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>    | <b>3,644,608.00</b>  | <b>38,586,994.01</b>  |
| 210816      | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/                                | 2,119,028.00         | 29,259,094.01         |
| 210818      | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/  | 1,525,580.00         | 9,327,900.00          |
| <b>III</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>         | <b>2,081,914.09</b>  | <b>1,245,351.88</b>   |
| <b>V</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>                   | <b>2,070,000.00</b>  | <b>1,100,000.00</b>   |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>2,070,000.00</b>  | <b>1,100,000.00</b>   |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | <b>2,070,000.00</b>  | <b>1,100,000.00</b>   |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                     | 2,070,000.00         | 1,100,000.00          |
| <b>VI</b>   | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>       | <b>-2,070,000.00</b> | <b>-1,100,000.00</b>  |
| <b>VIII</b> | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>           | <b>11,914.09</b>     | <b>145,351.88</b>     |
| 101         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                   | 0                    | 11,914.09             |
| 20          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                  | 11,914.09            | 157,265.97            |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Эдийн засгийн үзүүлэлт                 | хэмжих нэгж | 2022 оны гүйцэтгэл | 2023 оны төлөвлөгөө | 2023 гүйцэтгэл |
|---|--|-------------|--------------------|---------------------|----------------|
| 1 | 2                                      | 3           | 4                  | 5                   | 6              |
| 1 | Бараа бүтээгдэхүүн борлуулалтын орлого | мян.төг     | 69,987.0           | 156,718.2           | 165,019.6      |
|   | Бусад орлого                           | мян.төг     | 666.0              | 900.0               | 45,801.2       |
|   | Нийт орлого                            | мян.төг     | 70,653.0           | 157,618.2           | 210,820.8      |
|   | Үүнээс: цэвэр борлуулалт               | мян.төг     |                    |                     |                |
|   | Үйл ажиллагааны бус орлого             | мян.төг     |                    |                     |                |
| 2 | Нийт зардал                            | мян.төг     | 68,571.2           | 156,547.8           | 207,440.7      |
|   | Үүнээс : Удирдлагын зардал             | мян.төг     | 25,695.5           | 58,742.9            | 49,758.7       |
| 3 | Татварын өмнөх ашиг /алдагдал/         | мян.төг     | (9,553.8)          | (970.4)             | 2,880.3        |
| 4 | Цэвэр ашиг /алдагдал/                  | мян.төг     | (9,553.8)          | (970.4)             | 2,880.3        |
| 5 | Нийт ажиллагсдын тоо                   | мян.төг     | 12.0               | 12.0                | 12.0           |
| 6 | Нийт цалингийн сан                     | мян.төг     | 52,911.7           | 77,769.6            | 41,618.7       |
| 7 | Нэг ажилтаны дундаж цалин              | мян.төг     |                    |                     |                |
| 8 | Нийт өглөг                             | мян.төг     | 15,557.3           | 15,557.3            | 14,336.9       |
|   | Үүнээс: Богино хугацаат өр төлбөр      | мян.төг     | 15,557.3           | 15,557.3            | 14,336.9       |
|   | Урт хугацаат өр төлбөр                 | мян.төг     |                    |                     |                |